



СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ
ӨГӨХ БАЙГУУЛЛАГУУДАД

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Нам Ян Жугийн гудамж 32/1,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,
Цахим шуудан: info@nccd.gov.mn,
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2026. 09. 11 № 3-2/1244.

танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ)-ийн халдвартай амьдарч буй хүмүүс, тэдгээрийн гэр бүлд “Урлагаар эмчлэх” тусламж үйлчилгээ үзүүлэх нь ретровирусийн эсрэг эмчилгээг тууштай, үр дүнтэй үргэлжлүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

“Урлагаар эмчлэх” үйл ажиллагаа нь нийт 13,848,000 (арван гурван сая найман зуун дөчин найман мянга) төгрөгийн үнийн дүнтэй бөгөөд урлагийн сэтгэл засал хийх эрхтэй байгууллага, хамт олон, хувь хүнийг урлагийн сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд урьж байна. Сонирхож байгаа байгууллага, хамт олон үнийн саналаа 2026 оны 09 дугаар сарын 18-ны дотор ирүүлнэ үү.

Саналыг байгууллагын албан бичгээр баталгаажуулж холбогдох материалын бүрдэл (улсын бүртгэлийн гэрчилгээ, ижил төстэй ажлын гэрээ)-ийг ханган tender@nccd.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

ЗАХИРАЛ



С.ЭНХБОЛД

АЖЛЫН ДААЛГАВАР (TOR)

1. Сэтгэл зүйчид тавигдах шаардлага:

- Урлагийн сэтгэл засалчийн гэрчилгээтэй байх;
- Урлагийн сэтгэл засалчаар мэргэшил дээшлүүлсэн байх;
- Мэргэжилээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан байх;
- Нууцлал бүрэн хангаж ажиллах;
- Дээрх тохиолдлуудтай ажиллаж байсан бол давуу тал болно.

2. Орчны шаардлага:

- Гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай;
- Эрүүл ахуйн шаардлага хангасан байх;
- Үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх тав тухтай орчинг хангах;
- Ганцаарчилсан байдлыг хангасан байх;
- Аюулгүй байдлыг (нууцлал) бүрэн хангасан байх;
- Урлагийн тусгай хэрэглэгдэхүүн хэрэглэж болохуйц дуу тусгаарлагчтай байх.

3. Хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага:

- Урлагийн материал, хэрэглэгдэхүүнүүд аюулгүй байх;
- Хувь хүний онцлогт таарсан материал, хэрэглэгдэхүүнтэй байх;
- Хэрэглэхэд хялбар, тоо, хэмжээгээр хангалттай байх;
- Цэвэр, бүрэн бүтэн байдал, ариу цэвэр хангасан байх;
- Чөлөөтэй сонголт хийх боломжтой байх.